



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх газраас өгсөн чиглэлийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө”-г хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг 06 дугаар сарын 15, жилийн тайланг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Захиргаа удирдлагын газарт ирүүлж байхыг бүх газар, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000463



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2024 оны 05 дугаар сарын 08-ны
өдрийн 406 дугаар тушаалын хавсралт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах нэгж
1	<p>1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүргэмжийг нэмэгдүүлэх</p> <p>1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл; д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц; е/бусад (зохицуулалтын байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх</p>	<p>Шалуур үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> - Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; - Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүр тайлагнадаг байх; - Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. 	<p>06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p>
2	<p>1.2. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлуулах, шүтэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэл 110 дугаарыг оруулан сурталчлах</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. 	<p>06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>Бүх газар, нэгж</p>

3	1.3. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	- Авлигын эрдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; -Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.	06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	Бүх газар, нэгж
2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх				
4	2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	- Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; - Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; - Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.	06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	Бүх газар, нэгж
5	2.2. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших.	06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	Бүх газар, нэгж
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах				
6	3.1. Тухайн өөрийн ажиллагааны тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён эрсдэлд суурилсан хяналт	3.1.1. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан хяналт	06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15	ХШЗГ МУТА

	<p>гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>шалгалтыг хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх; 3.1.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зах зээлд шинээр үүсч буй эрсдэлийг үнэлж, холбогдох судалгааг гүйцэтгэсэн байх;</p>	<p>- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; - Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх.</p>	<p>06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15</p>	<p>ХШЗГ МУГА</p>
7					